

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Төмөр
замын газрын даргын 2025 оны ... сарын ...-ны
өдрийн дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

**ТӨМӨР ЗАМЫН ТЕХНИК, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛ, ЗУРАГ ТӨСӨЛ
БОЛОВСРУУЛАХ, МАГАДЛАЛ ХИЙХ, ТЕХНИК, ТЕХНОЛОГИЙН ХЯНАЛТ ТАВИХ ЗӨВЛӨХ
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖУРАМ**

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1. Энэхүү журмаар улсын төсөв, төрийн болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлэх төмөр замын суурь бүтцийг шинээр барих, өргөтгөл, их засвар хийхээр техник эдийн засгийн үндэслэл /цаашид “ТЭЗҮ” гэх/, зураг төсөл боловсруулах, эдгээрийн хийц, инженерийн шийдэл, тооцоо нь хүрээлэн буй орчин болон газар орны нөхцөлд зохицож байгаа эсэх, хөдөлгөөн зохион байгуулалт, аюулгүй байдал нь төмөр замын норм норматив, техникийн баримт бичгийн шаардлага хангасан эсэхэд мэргэжлийн дүгнэлт гаргах болон техник, технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулна.

1.2. ТЭЗҮ нь тухайн төслийг хэрэгжүүлэх боломж, үр ашиг, хэрэгцээ шаардлага, зардал, үр дүнг шинжлэх ухаанч үндэслэлтэйгээр үнэлж дүгнэсэн бичиг баримт байна.

1.3. Төмөр замын суурь бүтцийн зураг төсөл нь /цаашид “зураг төсөл” гэх/ төмөр замын суурь бүтцийг барих, засварлахад шаардагдах ТЭЗҮ, геологийн дүгнэлт, ус зүйн судалгаа, геодезийн хэмжилтийн тайлан, археологи, палеонтологийн судалгаа, байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, судалгаа, инженерийн тооцоо, нарийвчилсан зураг, төсөв, техникийн шаардлага зэргээс бүрдэнэ.

1.4. Төмөр замын тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага /цаашид “Төмөр замын газар” гэх/ нь төмөр замын зураг төсөлд магадлал хийх ажлыг зохион байгуулж хүн, хуулийн этгээдийг сонгон шалгаруулах, шинжээчийн эрх олгох ба шинжээчийн мэргэжлийн дүгнэлтийг нэгтгэн “Магадлалын нэгтгэсэн дүгнэлт” (МНД) гаргах ажлыг хариуцан гүйцэтгэнэ.

1.5. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр байгуулах төмөр замын зураг төслийг гадаадын хуулийн этгээд боловсруулах тохиолдолд Монгол Улсын тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдтэй хамтран гүйцэтгэх ба зураг төслийг Монгол Улсын эрх бүхий этгээдээр магадлуулсан байна.

1.6. Төмөр замын суурь бүтцийн барилгын ажлын техник, технологийн хяналт /цаашид “техник, технологийн хяналт” гэх/-ыг эрх бүхий мэргэжлийн байгууллага, захиалагчтай гэрээ байгуулсны үндсэн дээр хэрэгжүүлнэ.

1.7. Техник, технологийн хяналт гэдэг нь төмөр замын суурь бүтцийн барилга, засварын ажлыг батлагдсан зураг төсөл, төсөв, норм, норматив, стандарт, норм дүрэм, техникийн баримт бичгийн дагуу чанарын шаардлагад нийцэж хийж байгаа эсэхэд хяналт тавих, зөвлөгөө өгөх, ажлын гүйцэтгэлийг баталгаажуулж, мэргэжлийн түвшинд хянах үйл ажиллагааг ажиллагааг хэлнэ.

1.8. Зөвлөх үйлчилгээ гэдэг нь тухайн хүний эсвэл байгууллагын өмнө тулгарсан асуудлыг шийдвэрлэх, төлөвлөгөө боловсруулах, шийдэл санал болгох зорилгоор мэргэжлийн мэдлэг, туршлага, ур чадварт үндэслэн зөвлөгөө өгөх, дүгнэлт гаргах, туслалцаа үзүүлэх үйлчилгээг хэлнэ.

ХОЁР. ТЕХНИК-ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛ БОЛОВСРУУЛАХ

2.1. Төмөр замын ТЭЗҮ боловсруулахдаа дараах зарчмыг баримтална.

2.1.1. Шинжлэх ухаанч, нотолгоонд суурилсан байх зарчим: Бүх дүгнэлт, тооцоолол, шийдэл нь бодит мэдээлэл, судалгаа, тоон үндэслэлд тулгуурласан байна.

- 2.1.2. Иж бүрэн, цогц байдлыг хангах зарчим: Төслийн байршил, техник, эрэлт хэрэгцээ, техник, технологи, байгаль орчны мэдээлэл нь баталгаатай эх сурвалжаар нотлогдсон байна.
- 2.1.3. Үр ашиг, өгөөжийг үндэслэн дүгнэх зарчим: Төслийн хэрэгжилтийн санхүүгийн болон нийгэм-эдийн засгийн үр өгөөж, өгөөжийн түвшин зэргийг үндэслэн дүгнэлт гаргах, ашигтай хэрэгжих эсэхийг тодорхойлсон байна.
- 2.1.4. Хууль, норм, стандартын дагуу боловсруулах зарчим: Монгол Улсын хууль, тогтоомж, салбарын стандарт, норм дүрэмд нийцүүлэн боловсруулах, ТЭЗҮ-ийн бүтэц, аргачлал, тооцооллын үндэслэл нь техникийн зохицуулалт, үндэсний стандарттай нийцсэн байна.
- 2.1.5. Нээлттэй байдал, оролцоог хангах зарчим: Төслийн төлөвлөлтийн үе шатанд орон нутаг, иргэд, оролцогч талуудын санал, мэдээллийг тусгах, эрсдэл, нөлөөлөл бүхий асуудлуудад нийтийн оролцоонд тулгуурласан шийдэл санал болгосон байна.
- 2.1.6. Тогтвортой хөгжлийн зарчим: Байгаль орчинд хүлээн зөвшөөрөхүйц нөлөөлөлтэй байх, эрчим хүч, нөөц ашиглалтыг оновчтой шийдэж, ногоон хөгжлийн бодлогод нийцсэн байна.
- 2.1.7. Харьцуулалт, сонголтод суурилсан шийдвэр гаргах зарчим: Олон хувилбар судалж, тэдгээрийг техник, технологи, эдийн засаг талаас харьцуулж хамгийн оновчтой хувилбарыг сонгосон байна.
- 2.1.8. Эрсдэлийг үнэлж, бууруулах арга хэмжээг төлөвлөх зарчим: Болзошгүй эрсдэлийг урьдчилан тодорхойлж, түүнийг бууруулах, зохицуулах төлөвлөгөөтэй байна.
- 2.1.9. Бодлогын нийцэл, уялдаа холбоог хангах зарчим: Төсөл нь олон улс, бүс нутаг, улсын болон орон нутгийн хөгжлийн бодлого, дэд бүтцийн төлөвлөгөөтэй нийцсэн, салбар хоорондын уялдаа (зам, логистик, эрчим хүч, байгаль орчин) зэрэг тусгагдсан байна.
- 2.1.10. Тогтоосон хугацаа, төсөв, хүрээнд багтаан гүйцэтгэх зарчим: ТЭЗҮ боловсруулалт нь гэрээнд заасан хугацаа, төсвийн хүрээнд хийгдэж, гүйцэтгэлийн хариуцлагатай байна.
- 2.1.11. Шилэн байдал ба хариуцлагын зарчим: Судалгаа, дүн шинжилгээ, дүгнэлт, зөвлөмжүүдийг ил тод, баримтжуулсан, тайлагнах боломжтой байдлаар боловсруулсан байх;
- 2.2. Төслийн захиалагчийн хүсэлтээр урьдчилсан техник эдийн засгийн үнэлгээ болон ТЭЗҮ боловсруулж болно.
- 2.3. ТЭЗҮ-ийн тайланг боловсруулахдаа дараах иж бүрдэл хэсгүүдийг тусган боловсруулсан байна. Үүнд:
 - 2.3.1. Төслийн танилцуулга: Зорилго, цар хүрээ, хэрэгжүүлэх хугацааг тусгасан байна.
 - 2.3.2. Зах зээлийн судалгаа: Хэрэгцээ, өрсөлдөөн, хэрэглэгчдийн сегмент зэргийг багтаасан байна.
 - 2.3.3. Техникийн шийдэл: Байршил, хүчин чадал, тоног төхөөрөмж, технологийн шийдэл зэрэг багтсан байна.
 - 2.3.4. Санхүү, эдийн засгийн тооцоо: Хөрөнгө оруулалт, ашиг, зардал, өгөөжийг энэ хэсэгт тусгасан байна.
 - 2.3.5. Хууль, байгаль орчны үнэлгээг: Зохицуулалт, зөвшөөрөл, экологи, нийгмийн нөлөөлөл зэрэг байна.
 - 2.3.6. Эрсдэлийн үнэлгээ ба удирдлага: Болзошгүй эрсдэл, түүнийг бууруулах арга хэмжээ зэргээс багтсан байна.

2.4. ТЭЗҮ-ийн зорилго нь төсөл хэрэгжих боломжтой эсэхийг урьдчилан тогтоох, санхүү, эдийн засгийн үр өгөөжийг тооцоолох, техник, технологийн шийдлийг зөв тодорхойлох, эрсдэл, нөлөөллийг үнэлэх, хөрөнгө оруулагч, шийдвэр гаргагчдад шинжлэх ухааны нотолгоотой үндэслэл, дүгнэлт, танилцуулга зэрэг байна.

2.5. ТЭЗҮ-г төмөр замын тээврийн салбарын шинжлэх ухаан, технологийн дэд зөвлөлөөр хэлэлцүүлсэн байна.

- 2.5.1. Дэд зөвлөл нь дарга, дэд дарга, нарийн бичгийн дарга, гишүүд зэрэг (5) таваас доошгүй бүрэлдэхүүнтэй байна.
- 2.5.2. Дэд зөвлөлийн бүрэлдэхүүний (2/3) гурваны хоёроос доошгүй хувь нь докторын зэрэг эсхүл зөвлөх инженер байна.
- 2.5.3. Дэд зөвлөлөөр төмөр замын тээврийн салбарын ТЭЗҮ-ийн төслийн саналыг хэлэлцүүлж зөвлөмж гарган .
- 2.5.4. ТЭЗҮ-г Зам, тээврийн яамны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлөөр хэлэлцэж эцсийн шийдвэр гаргана.

ГУРАВ. ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ

3.1. Зураг төсөл боловсруулах үе шат

- 3.1.1. Зураг төслийн баримт бичиг боловсруулах ажил нэг ба хоёр үе шаттай байж болно.
- 3.1.2. Нэг үе шаттай зураг төслийг “Инженерийн нарийвчилсан зураг төсөл”, хоёр үе шаттай зураг төслийг “Техникийн зураг төсөл ба Инженерийн нарийвчилсан зураг төсөл” гэж ангилна.
- 3.1.3. Захиалагч байгууллага нь зураг төсөл боловсруулах үе шатыг зураг төсөл боловсруулах ажлын даалгавар болон зураг төслийн байгууллагатай байгуулах гэрээнд тодорхой тусгаж өгнө.

3.2. Зураг төсөл боловсруулах бэлтгэл ажил

- 3.2.1. Зураг төслийн бэлтгэл ажлыг хөрөнгө оруулагч, захиалагч талууд хариуцаж гүйцэтгэнэ;
- 3.2.2. Захиалагч зураг төсөл боловсруулах ажлын даалгаврын төсөлд шаардлагатай тохиолдолд холбогдох суурь бүтэц ашиглагч байгууллага, аж ахуйн нэгжүүдээс санал авч болно.
- 3.2.3. Нийтийн болон үйлдвэрлэлийн зориулалттай төмөр замын ТЭЗҮ, зураг төсөл ажлын даалгаврыг Төмөр замын газар, салбар замын зураг төслийн ажлын даалгаврыг Төслийн Захиалагч батална.
- 3.2.4. Захиалагч нь зураг төсөл боловсруулах ажлын даалгаварт зураг төсөл, төсөвт өртгийн нэгдсэн тооцоог заавал магадлан хянуулах талаар тодорхой тусгасан байна.
- 3.2.5. Инженерийн дэлгэрэнгүй тайлангийн агуулгын талаарх дэлгэрэнгүй шаардлагыг төслийн онцлогоос хамааруулан зураг төсөл боловсруулах ажлын даалгаварт тодорхой тусгасан байна.
- 3.2.6. Хөрөнгө оруулагч, Захиалагч нь зураг төслийн санхүүжилтийг хариуцах болон шаардлагатай тохиолдолд байгаль орчны асуудал, түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглахтай холбоотой зөвшөөрөл гэх мэт асуудлыг хариуцаж гүйцэтгэнэ.

3.3. Зураг төслийн техникийн шаардлага, тайлбар бичиг, төсвийн тооцоо

- 3.3.1. Зураг төслийн техникийн шаардлага гэж тухайн барилгын ажилд зохих инженерийн тооцоо, бүтээцийн хийц, материалын сонголт, аюулгүй байдал, норм стандарт, технологийн аргачлал, хяналтын шалгуур зэрэг бүх талыг хамааруулсан албан ёсны баримт бичиг байна. Тухайн хэрэгжиж буй төсөл

арга хэмжээ, газар нутгийн нөхцөл байдал, онцлогт тохируулан техникийн шаардлагыг төсөл болгонд тусгайлан боловсруулна.

- 3.3.2. Зураг төслийн тайлбар бичигт төслийн танилцуулга, төсөл хэрэгжүүлэх үндэслэл болон төслийн бүс нутгийн байгаль цаг уурын нөхцөл, төмөр замын суурь бүтцийн чигийн сонголт, төмөр замын дээд бүтэц, хиймэл байгууламжийн тооцоо, галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдал, хөдөлгөөн зохион байгуулалт, газар олголтын шийдвэр, дохиолол холбоо, ус хангамж, цахилгаан болон инженерийн шугам сүлжээний техникийн нөхцөл, зураг төсөл боловсруулахтай холбоотой хийсэн уулзалт, хурлын тэмдэглэл, албан тоот, акт, батлагдсан зураг төсөл боловсруулах ажлын даалгавар, магадлалын ерөнхий дүгнэлт болон холбогдох бусад мэдээллийг багтаасан байна.
- 3.3.3. Тайлбар бичгийн агуулгын талаарх дэлгэрэнгүй шаардлагыг төслийн онцлогоос хамааруулан зураг төсөл боловсруулах ажлын даалгаварт тодорхой тусгасан байна.
- 3.3.4. Төмөр замын суурь бүтцийг шинээр барих, өргөтгөх, их засварын ажлын тоо хэмжээг тодорхойлох, төсөвт өртгийг тооцохдоо төмөр замын тээврийн салбарт мөрдөгдөж буй төмөр замын барилга байгууламжийн ажлын суурь норм, БД 81-121-23 Төмөр замын зам, гүүрийн зураг төсөл боловсруулах жишиг үнэ, БД 81-122-23 Төмөр замын дээд бүтэц барих барилгын ажлын төсөв зохиох дүрэм, БД 81-123-23 Төмөр замын барилгын ажлын төсөв зохиох суурь норм, холбогдох техникийн баримт бичиг, стандарт, аргачлалын дагуу гүйцэтгэнэ.

3.4. Инженерийн нарийвчилсан зураг төсөл

- 3.4.1. Зураг төслийн баримт бичгийн иж бүрдэл нь Төмөр замын тээврийн тухай хуулийн 21.1-д заасан болон холбогдох норм, дүрэм, стандартад заасны дагуу хийгдсэн байна.
- 3.4.2. Төмөр замын суурь бүтцийг шинээр барих, өргөтгөл, их засварын ажлын техникийн шаардлага (ТШ) нь хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох норм, дүрэм, стандартад нийцсэн байна. Тухайн хэрэгжиж буй төсөл арга хэмжээ, газар нутгийн нөхцөл байдал, онцлогт тохируулан техникийн шаардлагыг төсөл болгонд тусгайлан боловсруулна.
- 3.4.3. Зураг төслийн байгууллага нь төслийн танилцуулга, төсөл хэрэгжүүлэх үндэслэл болон төслийн бүс нутгийн байгаль цаг уурын нөхцөл, байршил, чигийн сонголт, тэдгээрийн хувилбарууд, далан, хиймэл байгууламжийн тооцоо, тооцооны үр дүнгийн тайлбар, төмөр замын хөдөлгөөн зохион байгуулалт, аюулгүй байдал, газар олголтын шийдвэр, холбоо, ус хангамж, цахилгаан болон инженерийн шугам сүлжээний техникийн нөхцөл, зураг төсөл боловсруулахтай холбоотой хийсэн уулзалт, хурлын тэмдэглэл, албан тоот, акт, батлагдсан зураг төсөл боловсруулах ажлын даалгавар, Магадлалын нэгтгэсэн дүгнэлт болон холбогдох бусад мэдээллийг багтаасан инженерийн дэлгэрэнгүй тайлан (ИДТ) боловсруулна.
- 3.4.4. Төмөр замын суурь бүтцийг шинээр барих, өргөтгөл, их засвар, шинэчлэлтийн ажлын тоо хэмжээг тодорхойлох, төсөвт өртгийг тооцохдоо Төмөр замын барилга байгууламжийн ажлын төсвийн суурь норм болон БД 81-121-23 Төмөр замын зам, гүүрийн зураг төсөл боловсруулах жишиг үнэ, БД 81-122-23 Төмөр замын дээд бүтэц барих барилгын ажлын төсөв зохиох дүрэм, БД 81-123-23 Төмөр замын барилгын ажлын төсөв зохиох суурь нормын дагуу гүйцэтгэх ба төсөвт өртгийн нэгдсэн тооцоог (ТӨНТ) хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох норм, дүрэм, стандартын дагуу тооцож гүйцэтгэнэ.

3.5. Зураг төсөл боловсруулахад тавигдах шаардлага

- 3.5.1. Зургийн байгууллага нь инженер-геологи, геодези, археологи, палеонтологи, байр зүй, ус зүйн болон бусад шаардлагатай хайгуул, хэмжилт, инженерийн судалгааг хариуцан гүйцэтгэнэ.
- 3.5.2. Олон улсын гэрээнд тусгайлан зааснаас бусад тохиолдолд гадаадын хөрөнгө оруулалтаар барих төмөр замын төслийн зураг төслийг эрх бүхий гадаадын хуулийн этгээд боловсруулах нөхцөлд Монгол орны байгаль, цаг уурын нөхцөл, холбогдох хууль тогтоомж, норм, дүрэм, стандартын дагуу уг чиглэлээр тусгай зөвшөөрөл бүхий дотоодын аж ахуй нэгжтэй хамтран боловсруулах бөгөөд дараах шаардлагыг хангасан байна.
 - 3.5.2.1. Энэхүү журмын 1.5-д заасан байгууллагатай хамтран ажиллах тухай гэрээ байгуулсан байх;
 - 3.5.2.2. Зураг төслийг Монгол Улсын норм, норматив, техникийн баримт бичиг, стандартад нийцүүлэн боловсруулсан байх;
 - 3.5.2.3. Зураг төслийн эх хувь нь Монгол хэл дээр боловсруулсан байна.
- 3.5.3. Инженер-геологи болон геодезийн хэмжилт, судалгааны ажлын үр дүн, бодит байдлыг зургийн төслийн байгууллага хариуцна.
- 3.5.4. Зураг төслийн байгууллага нь мэргэжлийн тодорхой шийдэл гаргах шаардлагатай тохиолдолд Захиалгаас зөвлөмж зөвлөмж авч болно.

ДӨРӨВ. ЗУРАГ ТӨСЛИЙГ ЗӨВШИЛЦӨХ

- 4.1. Ажлын даалгаварт зураг төслийг зөвшилцөх байгууллагыг тодорхой зааж өгнө.
- 4.2. Зураг төсөлд тухайн замын чигийг дайран өнгөрч байгаа дараах байгууллагатай заавал зөвшилцсөн байна.
 - 4.2.1. Захиалагч;
 - 4.2.2. Орон нутгийн засаг захиргаа;
 - 4.2.3. Дэд бүтэц хариуцсан байгууллага;
 - 4.2.4. Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үүрэг хүлээсэн байгууллага;
 - 4.2.5. Газар олголт, төв суурин газрын хот байгуулалт, ерөнхий төлөвлөгөөний асуудал хариуцсан байгууллага;
 - 4.2.6. Дэд бүтцийн шугам сүлжээний ашиглалт, төлөвлөлт хариуцсан байгууллага (шаардлагатай тохиолдолд);
 - 4.2.7. Замын хөдөлгөөн зохион байгуулалтын газар (шаардлагатай тохиолдолд).
- 4.3. Зураг төслийг холбогдох хууль тогтоомж, норм, дүрэм, стандарт, техникийн баримт бичгийг баримтлан зөвшилцөж, акт, хурлын тэмдэглэл, холбогдох зөвлөмж, дүгнэлтийг инженерийн дэлгэрэнгүй тайланд тусгаж, хавсаргасан байна.

ТАВ. ЗУРАГ ТӨСЛИЙГ БАТАЛГААЖУУЛАХ

- 5.1. Зураг төслийн баримт бичгийн хуудас бүрийг зураг төсөл боловсруулсан байгууллагын дарга болон шалгасан инженер, зургийн ерөнхий инженер нар гарын үсэг зурж баталгаажуулсан байна.
- 5.2. Зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөл бүхий байгууллага нь өөрийн боловсруулсан зураг төслийн нүүр хуудсанд, тэмдэг дарж, гарын үсгээр баталгаажуулна.
- 5.3. Баталгаажсан зураг төсөлд өөрчлөлт оруулах шаардлага гарсан тохиолдолд зөвхөн зураг төсөл боловсруулсан байгууллагаас гаргасан албан ёсны тайлбар, дахин баталгаажуулалт хийсний үндсэн дээр хэрэгжүүлнэ.

ЗУРГАА. ЗУРАГ ТӨСЛИЙГ МАГАДЛАН ХЯНАХ, БАТАЛГААЖУУЛАХ

- 6.1. Зураг төслийг магадлан хянуулахад инженер-геологийн тайлан, инженерийн шугам сүлжээний зураг төсөл нь магадлан хянагдаж, баталгаажсан байх ба байгаль орчны

нарийвчилсан үнэлгээний тайланг ирүүлнэ. Захиалагч зураг төслийн иж бүрдэл нь ажлын даалгаварт заасан иж бүрдлийн шаардлагыг хангасан эсэхийг хянана.

6.2. Магадлан хянуулах зураг төсөл нь ажлын даалгавраас хамаарч дараах баримт бичгийн бүрдлийг хангасан байна. Үүнд:

- 6.2.1. Байршил тогтоосон шийдвэр;
- 6.2.2. Зураг төсөл боловсруулахад өгөгдсөн ажлын даалгаврууд (Захиалагч болон Зураг төслийн байгууллагаас гаргасан бүх судалгааны ажлын), биелэлтийн тайлан;
- 6.2.3. Зураг төслийн иж бүрдлийн хангасан талаарх Захиалагчийн тодорхойлолт;
- 6.2.4. ТЭЗҮ-ийн тайлан (урьдчилсан зураг төсөл);
- 6.2.5. Байгаль орчны нарийвчилсан үнэлгээний тайлан, дүгнэлт;
- 6.2.6. Инженер-геологийн тайлан;
- 6.2.7. Инженер-геологийн магадлалын дүгнэлт
- 6.2.8. Инженер-геодезийн хэмжилтийн тайлан;
- 6.2.9. Инженерийн нарийвчилсан зураг төсөл,
- 6.2.10. Ус зүйн судалгааны тайлан;
- 6.2.11. Цахилгаан, гэрэлтүүлгийн зураг төсөл;
- 6.2.12. Дохиолол, холбооны зураг төсөл;
- 6.2.13. Техникийн шаардлага;
- 6.2.14. Инженерийн дэлгэрэнгүй тайлан;
- 6.2.15. Техникийн нөхцөл;
- 6.2.16. Холбогдох мэргэжлийн байгууллагатай зөвшилцсөн акт, хурлын тэмдэглэл, зөвлөмж, дүгнэлт;
- 6.2.17. Төсөвт өртгийн нэгдсэн тооцоо гэх мэт.

6.3. Зураг төслийг дараах бүрэлдэхүүн хэсгүүдэд ангил шифрлэнэ. Үүнд:

- 6.3.1. Төмөр замын суурь бүтцийн зураг төсөл
 - Барилга, засварын ажил – шифр 11
 - Төсөв, үнэ бүрдлийн тооцоо – шифр 12
- 6.3.2. Гүүрийн зураг төсөл
 - Барилга, засварын ажил – Шифр 21
 - Төсөв, үнэ бүрдлийн тооцоо – шифр 22
- 6.3.3. Инженер-геологийн судалгаа
 - Инженер-геологийн судалгааны тайлан, дүгнэлт – шифр 31
- 6.3.4. Дохиолол, холбооны зураг төсөл
 - Барилга, засварын ажил – шифр 71
 - Төсөв, үнэ бүрдлийн тооцоо – шифр 72
- 6.3.5. Бусад барилга байгууламжийн зураг төсөл
 - Барилга, засварын ажил – шифр 91
 - Төсөв, үнэ бүрдлийн тооцоо – шифр 92

6.4. Энэ журмын 1.4-т заасан байгууллага нь зураг төслийг магадлан хянах үйл ажиллагааг дараах байдлаар зохион байгуулна. Үүнд:

- 6.4.1. Төмөр замын суурь бүтцийн ТЭЗҮ, инженерийн болон шугам сүлжээний нарийвчилсан зураг төсөл, төсөвт өртгийн нэгдсэн тооцоо, инженер-геологийн судалгааны тайлан, ус зүйн судалгааны тайланг тус тус магадлан хянаж, магадлалын нэгтгэсэн дүгнэлт гаргана;
- 6.4.2. Зураг төслийг магадлан хянах шаардлага хангасан иргэн, хуулийн этгээдийг сонгон шалгаруулж, шинжээчийн эрх олгох, гэрээ байгуулах, дүгнэх, мэргэжлийн дүгнэлт гаргах үйл ажиллагаанд хяналт тавьж, алдаа, зөрчил гаргасан шинжээчийн эрхийг цуцлах, хариуцлага тооцох арга хэмжээ авна;
- 6.4.3. Магадлал хийх эрхийн шинжээчд нэг жилийн хугацаатай олгох ба шинжээчийг жил бүрийн 1 дүгээр сарын эхний хагаст багтаан сонгон шалгаруулалтад хамруулна;
- 6.4.4. Магадлал хийх эрх олгосон иргэн эрүүл мэндийн болон бусад хүндэтгэх шалтгааны улмаас магадлал хийх боломжгүй болсон, өөрийн хүсэлтээр магадлал хийхээс татгалзсан тохиолдолд шинжээчийн сонгон шалгаруулалтыг дахин зохион байгуулна;
- 6.4.5. Зураг төслийн баримт бичигт эрх бүхий этгээдээр магадлал хийлгэж, магадлалын нэгтгэсэн дүгнэлт гарган баталгаажуулна;
- 6.4.6. Магадлан хянуулахаар ирүүлсэн хүсэлтийг судлан үзэж, энэ журмын 6.2-т заасан баримт бичгийн бүрдлийг бүрэн хангасан зураг төсөлд хяналтын хуудасны дагуу шинжээчийг томилох, зураг төслийн байгуулагатай магадлан хянах ажлын зардлыг тусгасан гэрээ байгуулах, хэрэгжилтэд хяналт тавина;
- 6.4.7. Зураг төслийн чанарыг дээшлүүлэх болон магадлан хянах үйл ажиллагааг боловсронгуй болгоход чиглэгдсэн уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж, зөвлөмж гарган хэрэгжүүлнэ;
- 6.4.8. Зураг төслийн баримт бичигт магадлан хянахтай холбоотой маргааныг таслах үйл ажиллагаанд мэргэжлийн баг томилон ажиллуулж, гаргасан зөвлөмжийг үндэслэн шийдвэр гаргана;
- 6.4.9. Зураг төслийг магадлан хянах шинжээчийн мэргэжлийн дүгнэлт болон Магадлалын нэгтгэсэн дүгнэлтийн маягт, зураг төслийг баталгаажуулах тэмдгийн загварыг батална;

6.4.10. Зураг төслийн мэдээллийн нэгдсэн сан үүсгэнэ.

6.5. Сүүлийн 3 жилийн хугацаанд магадлан хянагдаж, баталгаажсан зураг, төсвөөр барилгын ажлын гүйцэтгэгч нь сонгон шалгараагүй бол тухайн зураг, төсвийг хүчин төгөлдөр мөрдөгдөж буй стандарт, норм норматив, техникийн баримт бичгийн дагуу Захиалагчийн шийдвэрээр шинэчлэн дахин магадлан хянуулна.

6.6. Энэ журмын 6.4-т заасны хүрээнд зураг, төсвийг шинэчлэн боловсруулсан, мөн Төсвийн тухай хуулийн дагуу төсвийн жилд зарцуулах хэмжээгээр төсвийг хэсэгчлэн салгах, түүнийг дахин магадлан хянуулах тохиолдолд гарсан зардлыг төсөвт өртгийн нэгдсэн тооцоонд тусгах бөгөөд бусад тохиолдолд ТЭЗҮ, зураг төслийг боловсруулах зардлыг тусгахгүй.

6.7. Энэ журмын 6.4-д заасны хүрээнд захиалагч нь батлагдсан зургийг шинэчлэх шаардлагагүй гэж үзэж, зөвхөн төсөвт өртгийн нэгдсэн тооцоог шинэчлэх гэрээг зураг төслийн байгууллагатай байгуулна.

6.8. Хийц, технологийн онцлог, төвөгшилтэй шийдэл бүхий төмөр замын суурь бүтцийн зураг төсөлд “шинжээчийн баг”-ийг томилон ажиллуулж, зураг төслийн ажлын үе шат бүрт хяналт тавих замаар хэсэгчлэн болон үе шаттайгаар магадлан хянах үйл ажиллагааг зохион байгуулж, магадлалын нэгтгэсэн дүгнэлт гаргаж болно.

6.9. Батлагдсан зурагт Захиалагчийн шийдвэрээр өөрчлөлт оруулсан бол зургийн зөвхөн өөрчлөлт орсон хэсгийг магадлан хянах бөгөөд дараах баримт бичгийг үндэслэнэ. Үүнд:

- 6.9.1. Захиалагч байгууллагын зурагт өөрчлөлт оруулах шийдвэр (Үндэслэл, холбогдох баримт бичиг);
- 6.9.2. Зурагт өөрчлөлт оруулах гэрээ.

6.10. Зураг төслийг магадлан хянах зардлын хэмжээ нь тухайн зураг төсөл боловсруулах ажлын гэрээний үнийн дүнгээс 6%-аар тооцох бөгөөд үүнээс магадлан хянаж, мэргэжлийн дүгнэлт гаргах үйл ажиллагааг зохион байгуулах, хэлэлцүүлгийн болон бусад үйл ажиллагаанд зориулан 30%-ийг, магадлан хянах шинжээчийн цалинд 70%-ийг нь тус тус хуваарилж олгоно. Магадлан хянасан шинжээчид олгох хөлсийг зураг төслийн бүрэлдэхүүн хэсэг бүрт ногдох зардлын 80%-г зураг төслийн магадлалд, 20%-г төсөвт өртгийн нэгдсэн тооцооны магадлалд хуваарилна.

6.11. Ажлын тоо хэмжээг зураг төслийн дагуу зураг төслийн болон төсвийн орон тооны бус шинжээч магадлан хянана.

6.12. “Магадлалын нэгтгэсэн дүгнэлт”-ийг зураг төслийн байгууллагад хүлээлгэн өгөхөд магадлан хянах ажлын зардлын төлбөрийн баримт болон “Төмөр замын техникийн баримт бичиг, норм, стандартын сан”-гийн шимтгэлийн баримтыг үндэслэсэн, Зураг төслийн байгууллага, Захиалагч нь төлсөн байх шаардлагатай.

6.13. Зураг төслийг магадлан хянах шинжээч нь дараах шаардлагыг хангасан байна.

- 6.13.1. Зураг төслийн чиглэлээр 10-аас доошгүй жил ажилласан, тухайн чиглэлээр Зөвлөх инженер зэрэгтэй байна.
- 6.13.2. Төсөвт өртгийн нэгдсэн тооцоог магадлан хянах шинжээч нь 10-аас доошгүй жил төсөвчнөөр ажилласан, Тэргүүлэх эсвэл Хугацаагүй мэргэшсэн төсөвчин зэрэгтэй байна.
- 6.13.3. Шинжээч нь ёс зүйн талаар доголдолгүй, ашиг сонирхлын аливаа зөрчилгүй, тухайн зураг төслийг боловсруулсан байгууллагад шууд болон шууд бусаар харьяалагддаггүй, хувьцаа эзэмшдэггүй байна.
- 6.13.4. Шинжээч нь “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” хуулийн 18 дугаар зүйлийн 18.5.3 дахь заалтын шаардлагын дагуу холбогдох нөхцөлийг бүрдүүлж, 1.5-д заасан байгууллагад хүргүүлсэн байна.

6.14. Орон тооны бус шинжээчийг сонгон шалгаруулах.

- 6.14.1. Шинжээчийг өрсөлдөөний журмаар сонгох ба сонгон шалгаруулах үйл ажиллагаанд Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг авна. Шинжээчээр ажиллах хүсэлтийг энэ журмын 1.4-д заасан байгууллагад хүргүүлнэ. Төмөр замын газар нь шинжээчийг сонгон шалгаруулах ажлын хэсэг байгуулна.
- 6.14.2. Ажлын хэсэг нь сонгон шалгаруулахтай холбоотой аливаа асуудлыг хурлаар хэлэлцэж, шийдвэрлэнэ.
- 6.14.3. Ажлын хэсэг нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:
 - Хүсэлт гаргасан иргэний материалыг хүлээн авах, хэлэлцэх;
 - Сонгон шалгаруулалтыг зохион байгуулах;
 - Шалгаруулалтад тэнцсэн иргэнийг орон тооны бус шинжээчээр томилон ажиллуулах;
- 6.14.4. шалгаруулалтад орохыг хүссэн иргэдээс дор дурдсан материалыг тогтоосон хугацаанд хүлээн авч, бүртгэнэ. Үүнд:
 - Өргөдөл;
 - Ажил байдлын тодорхойлолт;
 - Биеийн байцаалт; (Төрийн албан хаагчийн 1-р маягт)

- 2% цээж зураг; (3х4 хэмжээтэй)
- Дээд боловсролын диплом, Эрдмийн зэрэг, Зөвлөх инженерийн эрхийн гэрчилгээ.

6.14.5. хүсэлтээ ирүүлсэн иргэдээс энэхүү журмын 4-р зүйлд заасан шаардлагыг харгалзан үзэж, сонгон шалгаруулалт явуулна. Сонгон шалгаруулалтын хурлын тэмдэглэл, дүгнэлтэд гишүүд гарын үсэг зурж, баталгаажуулсан байна.

6.14.6. Сонгон шалгаруулалтын хурлын тэмдэглэл, дүгнэлтийг үндэслэн Төмөр замын газарын даргын тушаал гарган, зураг төслийн бүрэлдэхүүн тус бүрт 3-аас доошгүй иргэнд 1 жилийн хугацаатай эрх олгож, орон тооны бус шинжээчээр томилно.

6.14.7. Шинжээчид зураг төслийн баримт бичигт магадлал хийх хувийн дугаар олгоно.

6.15. Шинжээч нь зураг төслийг магадлан хянасан бүрдэл хэсэг тус бүрт мэргэжлийн дүгнэлтийг хуанлийн 14 хоногт багтаан гаргаж, шаардлагатай хуудсуудад хувийн тэмдэг болон гарын үсгээр баталгаажуулах ба дүгнэлтээ 1.4-т заасан байгууллагад болон зураг төслийн байгууллагад цахимаар, мөн хэвлэмэл хэлбэрээр тухай бүр хүргүүлж ажиллана.

6.16. Тухайн төсөл арга хэмжээний цар хүрээ, хүчин чадал, ажлын тоо хэмжээнээс хамааруулан 1.4-д заасан байгууллага нь хүснэгт-1-д заасны дагуу тохирох тооны шинжээч эсвэл шинжээчийн баг, хуулийн этгээдийг томилно.

Хүснэгт-1

№	Төмөр замын зураг төсөл	Хүчин чадал	Томилгооны хэлбэр	Тайлбар
1	Төмөр замын суурь бүтэц	0-50 км	Шинжээч	
		50-100 км	Шинжээчийн ажлын хэсэг	
		100 км-ээс дээш	Хуулийн этгээд	
2	Гүүр, хоолой	0-400 у/м	Шинжээч	
		400 у/м-ээс дээш	Шинжээчийн ажлын хэсэг	

6.17. Зураг төслийн баримт бичигт магадлал хийх үйл явц нь дараах дараалалтай байна:

6.17.1. Зураг төслийн байгууллага нь цахимаар магадлал хийх албан хүсэлт ирүүлэх;

6.17.2. Зураг төсөл боловсруулах ажлын даалгавар болон холбогдох норм дүрэм, стандартын шаардлагад нийцсэн ТЭЗҮ-ийн тайлан, зураг төслийг цахимаар хүлээн авах;

6.17.3. Зураг төслийн бүрэлдэхүүн хэсэг тус бүрд эрх бүхий шинжээч, эсвэл шинжээчийн баг, хуулийн этгээдээр магадлал хийлгэх;

6.17.4. Зураг төсөлд магадлал хийгдэхээс өмнө инженер геологийн дүгнэлт магадлалаар баталгаажсан байх;

6.17.5. Шаардлагатай тохиолдолд магадлалын нэгтгэсэн дүгнэлтийн дагуу холбогдох өөрчлөлт, сайжруулалтыг төслийн баримт бичигт тусгуулах;

6.17.6. Магадлалын ерөнхий нэгтгэл гаргах.

6.18. Шинжээч нь зураг төслийг магадлан хянахдаа төмөр замын салбарын холбогдох дүрэм, журам, стандартын үндсэн шаардлага, нөхцөлүүдийг хангасан эсэхийг хянаж, мэргэжлийн дүгнэлт гарган холбогдох засвар өөрчлөлтийг тусгуулна. Үүнд:

6.18.1. Төмөр замын суурь бүтцийн байршил, чигийг тогтоосон шийдвэр, зураг төсөл боловсруулах ажлын даалгавар, техникийн нөхцөл, холбогдох мэргэжлийн байгууллагатай зөвшилцсөн байдал;

- 6.18.2. Инженерийн шийдэл, хийц бүтээц нь байгаль, цаг уурын ерөнхий өгөгдлүүд, хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа норм норматив, техникийн баримт бичиг, техник ашиглалтын түвшин тогтоох судалгааны ажлын дүгнэлт, инженер-геологийн судалгааны дүгнэлт, техникийн нөхцөлийн дагуу боловсруулсан эсэх;
- 6.18.3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, техник технологийн аюулгүй ажиллагаа, орчны эрүүл ахуйн норм, нормативын баримт бичгийн шаардлагыг хангуулсан эсэх;
- 6.18.4. Хөдөлгөөн зохион байгуулалт, галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлын шаардлагыг хангуулсан эсэх;
- 6.18.5. Инженерийн шийдлийн хувилбар, харьцуулсан тооцоо, сонгосон хувилбарын талаарх дүгнэлттэй эсэх;
- 6.18.6. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээ, техникийн шаардлагыг хангасан эсэх;
- 6.18.7. Байршил, чиглэл, төлөвлөлт, инженер-геологийн нөхцөл, хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөлөл, сонгосон хувилбарын талаар;
- 6.18.8. Эдийн засгийн үр ашиг, экологийн хор хөнөөлгүй байдал, ашиглалтын үеийн найдвартай ажиллагаа, нийгмийн ач холбогдол зэргийг харгалзан хөрөнгө оруулалтын үр ашгийн талаарх дүгнэлт гаргасан эсэх;
- 6.18.9. Шинжээчийн мэргэжлийн дүгнэлтэд хууль тогтоомж, норм нормативын баримт бичгийн шаардлагыг үндэслэн техникийн үндсэн шийдэл, эдийн засгийн үр ашиг, төсөвт өртгийн нэгдсэн тооцоонд өгсөн мэргэжлийн үнэлэлтийг ТЭЗҮ, зураг төсөлд нэмж тусгах буюу хасах, өөрчлөх асуудлын талаар товч, тодорхой тусгах бөгөөд эцсийн дүгнэлтэд шинжээч нь доорх асуудлыг тодорхойлсон байна. Үүнд:
- магадлан хянагдсан зургаар барилгын ажлыг хэрэгжүүлэх боломжтой эсэх,
 - магадлан хянагдсан төсөвт өртгийн нэгдсэн тооцооны эцсийн дүн.
- 6.19. “Магадлалын нэгтгэсэн дүгнэлт” нь төмөр замын суурь бүтцийн төлөвлөлт, инженерийн шийдлүүдэд өгөх мэргэжлийн үнэлгээ байх бөгөөд шинжээчийн мэргэжлийн дүгнэлтийн хамт хүчин төгөлдөр байна.
- 6.20. Магадлалын нэгтгэсэн дүгнэлт нь доорх агуулгыг багтаасан байна:
- 6.20.1. Төмөр замын суурь бүтцийн сонгосон байршил, техник эдийн засгийн үзүүлэлтүүд, зураг төслийн үндсэн төлөвлөлт, техникийн шийдэл, бүтээцийн талаар тусгасан товч санал, дүгнэлт
- 6.20.2. Боловсруулсан зураг төслийн сонгосон шийдэл, магадлалын явцад хийсэн нэмэлт өөрчлөлтөөс шалгаалах үр дүнгийн талаарх тодорхой санал, дүгнэлт
- 6.20.3. Эдийн засгийн үр ашиг, хөдөлгөөний аюулгүй байдал, экологийн хор хөнөөлгүй байдал, ашиглалтын үеийн ажиллагаа, байгууламжийн нийгмийн ач холбогдол, барилгын ажлын төсөвт өртгийн талаарх дүгнэлт гэх мэт.
- 6.21. Зураг төслийн магадлалын ажлын хугцааг тухайн төсөл арга хэмжээний хүчин чадлаас хамааруулан Төмөр замын газар болон магадлал хийх шинжээч эсвэл шинжээчийн багийн ахлагч, хуулийн этгээд нар харилцан тохиролцоно. Магадлал хийх хугацааг үндэслэлгүйгээр сунгахыг хориглоно.
- 6.22. Зураг төсөлд засвар оруулах шаардлагатай тохиолдолд шинжээчийн гаргасан мэргэжлийн дүгнэлтийн дагуу Зураг төслийн байгууллага зохих засварыг гүйцэтгэх бөгөөд тайлбарыг гаргаж, шинжээчид дахин хянуулснаар шинжээчийн хувийн тэмдэг болон гарын үсгээр баталгаажуулан 1.4-т заасан байгууллагад хүлээлгэн өгнө.
- 6.23. Шинжээчийн баталгаажуулсан мэргэжлийн эцсийн дүгнэлтийг хянаж, хүлээн авснаас хойш Төмөр замын газар нь ажлын 5 хоногт багтаан Магадлалын нэгтгэсэн дүгнэлтийг гаргана.

6.24. Магадлалын нэгтгэсэн дүгнэлтийг 2 хувь хийх бөгөөд магадлал хийгдсэн ТЭЗҮ, зураг төсөл, төсөвт өртгийн нэгдсэн тооцоог 1 хувийг Төмөр замын газрын даргын гарын үсэг, тэмдгээр баталгаажуулна.

ДОЛОО. ЗУРАГ ТӨСЛИЙГ ХЯНАХ, ХҮЛЭЭН АВАХ

7.1. Зураг төслийг хянаж хүлээн авахдаа Захиалагч зураг төслийн иж бүрдэл нь энэ журмын 3.3, 3.4 дугаар заалт, ажлын даалгаварт заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг хянана.

НАЙМ. ЗУРАГ ТӨСЛИЙГ ХАДГАЛАХ, МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН ҮҮСГЭХ

8.1. Магадлан хянагдаж, батлагдсан зураг төслийг нэг (1) хувь, Магадлалын нэгтгэсэн дүгнэлтийг 2 хувь үйлдэж, магадлалын тэмдэгээр баталгаажуулна. Магадлалын нэгтгэсэн дүгнэлтийг энэ журмын 1.4-д заасан байгууллага 1 эх хувийг Монгол Улсын Архивын тухай хууль болон бусад холбогдох журмын дагуу хадгална.

8.2. Зураг төслийн байгууллага нь магадлан хянагдаж, батлагдсан зураг, төсвийг *pdf, *dwg, *kmz, *shp болон *res өргөтгөлтэйгөөр энэ журмын 1.4-д заасан байгууллагад батлагдсан өдрөөс хойш хуанлийн 3 хоногийн дотор хүлээлгэн өгнө.

8.3. Энэ журмын 1.4-д заасан байгууллага нь магадлан батлагдсан зураг төслийг холбогдох материалын хамт зураг төслийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэн оруулж, мэдээллийг Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад жил бүр жагсаалтаар хүргүүлнэ.

ЕС. ТЕХНИК, ТЕХНОЛОГИЙН ХЯНАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

9.1. Зөвлөх нь төмөр замын суурь бүтцийн барилгын ажлыг Төмөр замын тээврийн тухай хуулийн 11 дүгээр зүйл 11.1.5, 10 дугаар зүйл 10.2.8, 43 дугаар зүйл 43.1 дэх хэсэг болон төслийн батлагдсан зураг төсөл, төсөв, захиалагч, гүйцэтгэгч хооронд байгуулсан гэрээний нөхцөл зэрэг баримт бичиг, шаардлагад нийцүүлэн гүйцэтгэж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллана:

9.2. Зөвлөх нь хяналт шалгалтаа дараах аргачлалаар хэрэгжүүлнэ:

9.2.1. Барилгын үе шат бүрийн ажлыг газар дээр нь хянан шалгах;

9.2.2. Ил, далд ажлын акт бичиг баримт, гүйцэтгэлийн зураг төсөлтэй тулгах;

9.2.3. Төслийн явц, гүйцэтгэлийг долоо хоног бүр тайлагнаж, шаардлагатай тохиолдолд холбогдох арга хэмжээний саналыг Захиалагчид танилцуулах;

9.3. Хяналт шалгалтын явцад Зөвлөх нь дараах эрхтэй:

9.3.1. Зураг төсөл, норм, стандарт зөрчсөн ажил гүйцэтгэлд баталгаажуулалт олгохоос татгалзах;

9.3.2. Тохирлын үнэлгээ, материалын шинжилгээний дүгнэлт шаардах;

9.3.3. Шаардлагатай бол ажлын зогсолт санал болгох

9.4. Зөвлөх нь дараах мэдээллийг тогтмол бүрдүүлж, хөтөлнө:

9.4.1. Хяналт шалгалтын өдөр тутмын тэмдэглэл;

9.4.2. Ажлын явцын фото зураг, байршил тогтоох систем ашигласан координат

9.4.3. Зөрчил, алдааны бүртгэл, шаардлагын акт;

9.4.4. Тайлан, тэмдэглэл, зөвлөмжийн албан бичиг;

9.5. Хяналтын явцад илэрсэн зөрчил, алдааг дараах журмаар шийдвэрлэнэ:

9.5.1. Албан шаардлага хүргүүлж засварлах үүрэг өгөх;

9.5.2. Засвар хийсний дараа дахин хяналт хийж баталгаажуулах

9.5.3. Гүйцэтгэлд шаардлага хангаагүй ажилд төлбөрөөс татгалзах талаар Захиалагчид мэдэгдэх;

- 9.6. Хяналтын баримт бичиг, маягтыг батлагдсан загварын дагуу ашиглана.
 - 9.6.1. Зөвлөх нь хяналт шалгалтын маягт, тайлангийн загварыг хууль, гэрээ, журмын дагуу баримтална;
 - 9.6.2. Гадаадын зээл, тусламжийн төслүүдийн хувьд олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол мөн адил хэрэгжинэ;
- 9.7. Зөвлөх нь дараах ерөнхий шаардлагыг хангасан, хуульд заасан тусгай зөвшөөрөлтэй байх ёстой.
 - 9.7.1. Монгол Улсад бүртгэлтэй, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх эрхтэй хуулийн этгээд байх;
 - 9.7.2. Төмөр замын суурь бүтцийн барилга угсралт, техникийн хяналтын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байх;
 - 9.7.3. Үйл ажиллагаа нь хөндлөнгийн, хараат бус, ашиг сонирхлын зөрчилгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн байх.
- 9.8. Зөвлөхийн бүрэлдэхүүн дараах чиглэлийн мэргэжилтнүүдээс бүрдэнэ.
 - 9.8.1. Төмөр замын барилгын инженер, бүтээцийн инженер;
 - 9.8.2. Цахилгаан хангамж, дохиолол, холбоо, автоматжуулалтын инженер (шаардлагатай төслүүдэд);
 - 9.8.3. Геотехникийн болон материал судлалын мэргэжилтэн;
 - 9.8.4. Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны хяналтын инженер;
 - 9.8.5. Шаардлагатай тохиолдолд холбогдох нарийн мэргэжлийн зөвлөх (жишээ нь: уурын зуух, мэдээлэл технологи гэх мэт);
- 9.9. Зөвлөхийн мэргэжилтнүүд нь дараах мэргэшлийн шаардлагыг хангасан байна.
 - 9.9.1. Бакалавр ба түүнээс дээш боловсролтой;
 - 9.9.2. Мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан туршлагатай;
 - 9.9.3. Тухайн чиглэлийн гүйцэтгэсэн төслийн туршлагатай;
 - 9.9.4. Зөвлөх байгууллага нь дараах техникийн чадамж, нөөцтэй байна;
 - Шаардлагатай хэмжилтийн багаж, төхөөрөмж, программ хангамж;
 - Ажлын тайлан, бүртгэл, зураг хөтлөх техник хэрэгсэл (GPS, фото камер, дрон, принтер, цахим платформ г.м.);
 - Судалгаа шинжилгээ болон лабораторийн шинжилгээний хамтын ажиллагаатай, гэрээт байгууллагатай байх.
- 9.10. Зөвлөх үйлчилгээ үзүүлэх багийг гүйцэтгэлд нөлөөлөхүйц өөрчлөх тохиолдолд.
 - 9.10.1. Захиалагчтай урьдчилан зөвшилцөн, тухайн албан тушаалд тохирох ижил түвшний мэргэжилтнийг орлох ёстой;
 - 9.10.2. Зөвлөх багийн өөрчлөлтийн тухай мэдээллийг албан ёсоор баталгаажуулсан баримтаар нотлох;
- 9.11. Зөвлөх нь үйл ажиллагаагаа ил тод, баримтжуулсан байдлаар хэрэгжүүлэх бөгөөд дараах ёс зүйн зарчмыг мөрдөнө;
 - 9.11.1. Нууцлал, хөндлөнгийн байдлыг чанд сахих;
 - 9.11.2. Захиалагчийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхлыг хөндөхгүй байх;
 - 9.11.3. Илэрсэн зөрчлийг мэргэжлийн үнэн зөв үндэслэлээр тайлбарлаж, нотлох баримтаар баталгаажуулж ажиллах;
- 9.12. Захиалагч нь дараах эрх эдэлнэ.

- 9.12.1. Төслийн явцад Зөвлөхөөс хяналт, үнэлгээ, тайлан, санал авах, шаардлагатай мэдээллийг шаардах;
 - 9.12.2. Хяналтын явцад илэрсэн зөрчлийг арилгуулах талаар Зөвлөхийн хүргүүлсэн шаардлагыг үндэслэн гүйцэтгэгчид арга хэмжээ авах.
 - 9.12.3. Хуулийн хүрээнд гүйцэтгэлд санхүүжилт олгох, хойшлуулах, зогсоох шийдвэрийг гаргах;
 - 9.12.4. Зөвлөх үйлчилгээний тайлан, санал, дүгнэлтийг үндэслэн техникийн зөвлөлөөр хэлэлцүүлэх;
 - 9.12.5. Зөвлөхийн тайлагнал, хяналтын явцад зөрчил илэрсэн тохиолдолд хөндлөнгийн шинжээч томилуулах, давхар хяналт явуулах;
 - 9.12.6. Зөвлөх багт орсон ажилтны мэргэжлийн чадамжид эргэлзээ гарсан тохиолдолд дахин үнэлгээ хийлгэхийг шаардах.
- 9.13. Захиалагч нь дараах үүрэг хүлээнэ:
- 9.13.1. Барилгын ажлын зураг төсөл, техникийн шаардлага, батлагдсан төсөв, гэрээний баримт бичиг болон бусад холбогдох материалыг Зөвлөхөд хугацаанд нь бүрэн, албан ёсоор шилжүүлэх;
 - 9.13.2. Хяналт тавих нөхцөлийг бүрдүүлж, Зөвлөхийн багийг барилгын талбайд чөлөөтэй нэвтрэх, ажиллах боломжийг хангах;
 - 9.13.3. Зөвлөхийн санал, дүгнэлтийг үндэслэн хүлээн авах, шаардлагатай арга хэмжээг гүйцэтгэгчид хэрэгжүүлэх;
 - 9.13.4. Хуулийн дагуу Зөвлөх үйлчилгээний хөлсийг гэрээнд заасан нөхцөлөөр тооцон олгох;
 - 9.13.5. Гэрээнд заасан тохиолдолд Зөвлөх үйлчилгээний багийг солих, шинэчлэхтэй холбоотой зөвшилцөл хийх;
 - 9.13.6. Зөвлөхийн үйл ажиллагаанд хэрэгцээтэй нэмэлт мэдээлэл, баримт бичгийг тухай бүрд нь гаргаж өгөх;
 - 9.13.7. Хяналтын дүн, тайланг хадгалах, төслийн архивд оруулах зохион байгуулалт хийх.
 - 9.13.8. Суурь бүтцийн бүтээн байгуулалтын ажлын гэрээний хэрэгжилтийн явцад Зөвлөх нь хүлээсэн үүргээ биелүүлээгүй, тухайн ажлыг зураг, төсвийн дагуу холбогдох стандарт, норм, дүрэмд нийцүүлэн чанартай хийж гүйцэтгүүлээгүй тохиолдолд Захиалагч нь Зөвлөхөд төлөх төлбөрийг санхүүжүүлэхээс татгалзаж, гарсан зөрчил дутагдлыг бүрэн арилгаж, биелэлтийг гаргаж ирүүлэх хүртэлх хугацаанд санхүүжилтийг олгохгүйгээр түр зогсооно.
- 9.14. Зөвлөхийн эрх:
- 9.14.1. Техник, технологийн хяналтын ажлыг бие даан, хараат бус байдлаар гүйцэтгэх;
 - 9.14.2. Барилгын ажлын гүйцэтгэлд зураг төсөл, норм, стандартын шаардлага зөрчигдсөн тохиолдолд баталгаажуулалт олгохоос татгалзах;
 - 9.14.3. Ил, далд ажлын акт, баримт бичигтэй тулган шалгах, шаардлагатай тохиолдолд нэмэлт мэдээлэл, баримт шаардах;
 - 9.14.4. Барилгын ажлын явц, материалын чанар, тоног төхөөрөмжийн тохирлын үнэлгээ, лабораторийн шинжилгээний дүгнэлт шаардах;
 - 9.14.5. Илэрсэн зөрчил, алдааг арилгуулах албан шаардлага хүргүүлэх, засвар дуусахаас нааш дараагийн үе шат руу шилжихийг хориглох санал гаргах;
 - 9.14.6. Ажлын тодорхой хэсгийг түр зогсоох талаар Захиалагчид зөвлөмж өгөх;

9.14.7. Хяналтын явцад илэрсэн зөрчлийг Захиалагч, холбогдох хяналтын байгууллагад мэдээлэх.

9.15. Зөвлөхийн үүрэг:

- 9.15.1. Төмөр замын суурь бүтцийн барилгын ажлын бүх үе шатанд техник, технологийн хяналт тавих;
- 9.15.2. Барилгын явц, ажлын чанар, норм стандартын хэрэгжилт, аюулгүй байдлыг газар дээр нь шалгах, бичгээр тэмдэглэх;
- 9.15.3. Хяналтын ажлын өдөр тутмын тэмдэглэл, зөрчил, акт, тайлан, зөвлөмж, фото зураг, газарзүйн байршлын координат тэмдэглэл зэрэг бүх баримт бичгийг бүрдүүлэн хөтлөх;
- 9.15.4. Долоо хоног тутам ажлын явцын тайланг Захиалагчид танилцуулах;
- 9.15.5. Илэрсэн зөрчил, алдааг цаг тухайд нь Захиалагчид мэдэгдэж, засвар арга хэмжээний санал хүргүүлэх;
- 9.15.6. Гүйцэтгэгчийн гүйцэтгэлийг чанар, хугацаа, зураг төсөвт нийцсэн байдлаар үнэлж, санал дүгнэлт гаргах;
- 9.15.7. Ажлын хүлээлцэх болон ашиглалтад хүлээн авах үе шатанд техникийн шаардлага хангасан эсэх талаар бүрэн дүгнэлт гаргаж, албан бичгээр баталгаажуулах;
- 9.15.8. Хяналтын баримт бичгийг журамд заасан маягтын дагуу албажуулан хөтлөх;
- 9.15.9. Зөвлөх үйлчилгээний явцад гарсан мэдээлэл, баримтыг хуулийн хүрээнд нууцлах, хөндлөнгийн байдлыг баримтлах, ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллах.

9.16. Зөвлөх туслан гүйцэтгэгчтэй хамтран ажиллах тохиолдолд баримтлах нөхцөл, хариуцлага:

- 9.16.1. Зөвлөх нь хяналтын үйл ажиллагааныхаа тодорхой хэсгийг гэрээний дагуу эрх бүхий туслан гүйцэтгэгч байгууллагаар гүйцэтгүүлж болох бөгөөд энэ тухай Захиалагчтай урьдчилан зөвшилцөн, албан ёсоор баталгаажуулсан байна;
- 9.16.2. Туслан гүйцэтгэгч нь тухайн чиглэлээр мэргэшсэн, туршлагатай, холбогдох зөвшөөрөл, чадамжтай байх ёстой;
- 9.16.3. Туслан гүйцэтгэгчийн гүйцэтгэсэн ажлын үр дүнг үндэслэн Зөвлөх нь эцсийн тайлан, дүгнэлтэд хариуцлага хүлээнэ;
- 9.16.4. Туслан гүйцэтгэгчийн буруугаас үүдэн гарсан зөрчил, хохиролд Зөвлөх хуулийн болон гэрээний хариуцлага хүлээнэ;

9.17. Илэрсэн зөрчил арилгах хугацаа, давтан зөрчилд авах арга хэмжээ:

- 9.17.1. Зөвлөхөөс гаргасан албан шаардлага, зөрчлийн акт-ын дагуу гүйцэтгэгч нь 3–7 хоногийн дотор зөрчлийг арилгах арга хэмжээ авах үүрэгтэй. Хугацааг тухайн зөрчлийн шинж чанар, аюулгүй байдалд үзүүлэх нөлөөнд үндэслэн Зөвлөх тодорхойлно;
- 9.17.2. Засвар, залруулга хийсний дараа Зөвлөх дахин хяналт хийж, баталгаажуулсан дүгнэлт гаргана;
- 9.17.3. Хэрэв нэг төрлийн зөрчил 2-оос дээш удаа давтагдсан, эсвэл засвар хийхгүйгээр үл тоомсорлосон тохиолдолд дараах арга хэмжээ авна:
 - Захиалагчид албан мэдэгдэл хүргүүлж, хүлээлгэх санхүүгийн шийтгэлийн саналыг дэвшүүлэх;
 - Төслийн тухайн хэсгийн ажлыг түр зогсоох санал тавих;

- Хяналтын тайланд “шаардлага хангаагүй” гэдэг дүгнэлт гаргаж, хүлээн авахгүй байх үндэслэл болгох;
- Хуулийн байгууллагад мэдэгдэх буюу мэргэжлийн хяналтын байгууллагад санал хүргүүлэх;

АРВАН ГУРАВ. ХАРИУЦЛАГА

13.1. Зураг төслийн алдааг зураг төсөл боловсруулсан байгууллага буюу Зохиогч хариуцах ба зураг төслийн техникийн шийдэл болон төсөвт өртгийн нэгдсэн тооцооны талаар гаргасан мэргэжлийн дүгнэлтийн алдааг магадлан хянасан Шинжээч хариуцна.

13.2. Зураг төслийг магадлан хянах үйл ажиллагааг зохион байгуулахтай холбоотой гаргасан алдаа, зөрчлийг энэхүү журмын 1.4-т заасан байгууллага хариуцна.

13.3. Төр, хувийн хэвшлийн түншлэлээр баригдах болон Хувийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төмөр замын суурь бүтцийн зураг, төсвийг өөрчлөх, шинэчлэх тохиолдолд Төмөр замын газраас холбогдох шийдвэрийг гаргуулсан байна.

13.4. Монгол Улсын нутаг дэвсгэрт баригдах төмөр замын суурь бүтцийн инженерийн нарийвчилсан зургийг боловсруулсан байгууллага нь Монгол улсын геодезийн сүлжээний цэгтэй холбогдсон объектын байршил, чигийн /трасс/ дагууд байгаа хэвтээ хяналтын цэгийн байршил, зай хэмжээ, өндөржилтийг барилгын ажлыг эхлүүлэх шатанд Захиалагч, Зөвлөх, Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөлд заавал хүлээлцнэ.

13.5. Барилгын ажлын явцад зураг төслөөс шалтгаалсан алдаа гарсан, алдааг Төмөр замын газрын салбарын хяналт шалгалтын эрх бүхий этгээд акт тогтоосон тохиолдолд гэрээ болон холбогдох хууль журамд заасны дагуу зураг төслийг боловсруулсан байгууллагаар гарсан хохирлыг барагдуулах, тусгай зөвшөөрлийг цуцалж, хар жагсаалтад оруулах асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлэх арга хэмжээ авна.

13.6. Шинжээч нь энэхүү журам ба гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа норм, норматив, стандартыг зөрчсөн, алдаатай дүгнэлт гаргасан, зураг төслийн техникийн буруу шийдлийг засаж, залруулаагүй, мэргэжлийн болон ёс зүйн зөрчил удаа дараа гаргасан тохиолдолд шинжээчийн эрхийг цуцлах хүртэл арга хэмжээ авна.

13.7. Шинжээч болон нэгтгэсэн дүгнэлт нь Төмөр замын тээврийн тухай хууль тогтоомж, стандарт, норм, нормативыг зөрчсөн төмөр замын суурь бүтцийн барилгын ажлын явцад болон ашиглалтын хэвийн нөхцөлийг алдагдуулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол Зөрчлийн тухай хуулийн холбогдох зүйлд заасны дагуу шийтгэл ногдуулна.

13.8. Зөвлөх дараах тохиолдолд хариуцлага хүлээнэ.

13.8.1. Хяналтын явцад илэрсэн зөрчил, алдаа, техникийн доголдлыг мэдэгдэлгүйгээр нуун дарагдуулсан;

13.8.2. Баталгаажуулж гарын үсэг зурсан ажил нь стандарт, норм, зураг төсөлд нийцээгүй нь батлагдсан;

13.8.3. Хараат бус байдал алдагдсан, ашиг сонирхлын зөрчилд орсон нь нотлогдсон;

13.8.4. Хуурамч тайлан, баримт бүрдүүлсэн, эсвэл ажил хийгдээгүй байхад хийсэн мэт дүгнэлт гаргасан;

13.8.5. Хяналтын ажлаа гүйцэтгээгүй буюу хугацаанд нь тайлагнаагүй.

13.8.6. Хариуцлагын хэлбэр нь Хохирлыг нөхөн төлүүлэх, Санхүүгийн торгууль, Гэрээг цуцлах, Мэргэжлийн байгууллагаар дамжуулан эрх зүйн болон ёс зүйн хариуцлага хүлээлгэх зэрэг хэлбэрээр шийдвэрлүүлнэ.

13.9. Захиалагч дараах тохиолдолд хариуцлага хүлээнэ.

13.9.1. Зөвлөхийн үйл ажиллагааг санаатайгаар саатуулсан, мэдээлэл хүргүүлээгүй;

13.9.2. Зөвлөхийн санал, шаардлагыг үл хэрэгсэн, зөрчлийг арилгаагүйгээр ажлыг үргэлжлүүлсэн;

13.9.3. Санхүүгийн гэрээний дагуу хөлсийг хугацаанд нь олгоогүй, гүйцэтгэлтэй харьцангуй үндэслэлгүй зогсоосон;

13.9.4. Зөвлөхийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс хууль бус нөлөөлөл үзүүлсэн;

- 13.9.5. Хариуцлагын бус шийдвэр гарган, төслийн чанарт сөрөг нөлөө үзүүлсэн;
- 13.9.6. Хариуцлагын хэлбэр нь Хуульд заасан сахилгын арга хэмжээ авах, Хохирол үүсгэсэн бол хариуцлага хүлээх болон Хөндлөнгийн хяналт шалгалтад орох үндэслэл болно.
- 13.10. Гуравдагч этгээд, гүйцэтгэгчийн зүгээс зөрчил гаргасан тохиолдолд:
 - 13.10.1. Зөвлөх нь тухайн зөрчлийг илрүүлэн албан шаардлага хүргүүлж, гэрээнд заасны дагуу Засгийн газар, холбогдох байгууллагад мэдэгдэх;
 - 13.10.2. Давтан зөрчил илэрсэн тохиолдолд хяналтын тайланд “шаардлага хангаагүй” гэсэн дүгнэлт өгч, Захиалагчид мэдэгдэнэ;
 - 13.10.3. Хуулийн байгууллагад шилжүүлэх үндэслэлтэй тохиолдолд баримтыг бүрдүүлэн хүргүүлнэ.
- 13.11. Зөвлөх, Захиалагч болон Гүйцэтгэгчийн аль нэг нь дараах тохиолдолд нэгдсэн хариуцлага хүлээнэ:
 - 13.11.1. Хууль, журам, олон улсын гэрээнд заасан нөхцөлийг зөрчиж, төслийн чанар, аюулгүй байдалд эрсдэл учруулсан;
 - 13.11.2. Техник, технологийн осол, гэмтэл гарч хүний амь нас, эд хөрөнгөд хохирол учирсан тохиолдолд буруутай этгээдийг хууль, гэрээний хүрээнд хариуцлагад татна.

---oOo---

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Төмөр
замын газрын даргын 2025 оны ... сарын ...-ны
өдрийн дугаар тушаалын хоёрдугаар
хавсралт

БАТЛАВ:
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ
АГЕНТЛАГ ТӨМӨР ЗАМЫН ГАЗРЫН
ДАРГА

БАТЛАВ:
“.....” ХХК-НЫ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

.....
.....

.....
.....

ЗУРАГ, ТӨСЛИЙН БАРИМТ БИЧИГТ МАГАДЛАЛ ХИЙХ АЖЛЫН ГЭРЭЭ

20... оны ... сарын ... өдөр

Дугаар

Улаанбаатар хот

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1. Монгол Улсын “Төмөр замын тээврийн тухай хууль”, “Иргэний хууль”-ийн 343 дугаар зүйл, Төмөр замын газрын даргын 2025 оны ... дүгээр тушаалаар батлагдсан “Төмөр замын техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах, магадлал хийх, техник, технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээний журам”-ыг үндэслэн Төмөр замын суурь бүтцийн зураг төслийн баримт бичигт магадлал хийх ажлын хүрээнд Захиалагч, Гүйцэтгэгчтэй холбогдон гарах харилцааг зохицуулахад энэхүү гэрээний зорилго оршино.

1.2. Нэг талаас Гүйцэтгэгчийг төлөөлж Төмөр замын газрын (цаашид Гүйцэтгэгч” гэх) нөгөө талаас Захиалагчийг төлөөлж магадлал хийлгэх хүсэлт гаргасан Зураг төслийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэн (цаашид “Захиалагч” гэх)-ийг төлөөлж - ийн ... нар харилцан тохирч энэхүү гэрээг байгуулав.

1.3. Зураг төслийн талаарх мэдээлэл

Зураг төслийн захиалагч: “...”

Хөрөнгө оруулагч:

Зураг төслийн гүйцэтгэгч:

Объектын байршил:

Объектын нэр:

/улсын төсөв, гадаадын хөрөнгө оруулалт/

Магадлалын ажлын төлбөр: төгрөг

/Мөнгөн дүнг үсгээр, банкны төлбөрийн даалгаварт гэрээний дугаарыг бичсэн байна/
(.....)

1.4. Зураг төслийн магадлалын ажилд Төмөр замын газрын даргын 2025 оны ... дүгээр тушаалаар батлагдсан “Төмөр замын техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах, магадлал хийх, техник, технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээний журам”-ын 6 дугаар зүйлийн 6.16 дахь заалтын дагуу хуанлийн 14 хоногт багтаан магадлал хийх ажлыг хамтран зохион байгуулахаар харилцан тохиролцов.

1.5. Зураг төслийн баримт бичигт магадлал хийх ажлыг зохион байгуулах, магадлал хийлгэх ажлын хөлсийг Захиалагч нь Гүйцэтгэгчийн банк тоот дансанд гэрээ байгуулснаас хойш ажлын 3 хоногт багтаан шилжүүлсэн байна. Ажлын цар хүрээ, тоо хэмжээнээс хамааран томоохон хэмжээний ажлын хувьд урьдчилгаа гэрээний үнийн дүнгийнийг төлж гэрээ байгуулна.

ХОЁР. ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

2.1. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг – Төмөр замын газрын даргын 2025 оны ... дүгээр тушаалын ... дүгээр хавсралтаар батлагдсан “Зураг төслийн баримт бичгийн бүрдлийг хянах маягт”-ын загварын дагуу Захиалагчаас тухайн ажилд шаардагдах материал, холбогдох хууль эрх зүйн баримт бичгийг гаргуулж авах.

2.2. Зураг төслийн баримт бичгийн бүрдлийн шаардлага хангаагүй тохиолдолд Захиалагчид албан тоотоор хариу өгөх.

2.3. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг – Төмөр замын газрын даргын 2025 оны ... дүгээр тушаалаар батлагдсан “Төмөр замын техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах, магадлал хийх, техник, технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээний журам”-ын 6 дугаар зүйлийг үндэслэн магадлал хийлгэх ажлыг зохион байгуулах.

ГУРАВ. ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

3.1. Захиалагч орон тооны бус Шинжээчийн гаргасан дүгнэлтийг хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд дахин Шинжээч томилуулах санал оруулах.

3.2. Томилогдсон орон тооны бус Шинжээч магадлалын ажлыг гүйцэтгэх боломжгүй тохиолдолд Захиалагчид энэ талаар ажлын 1 хоногийн дотор мэдэгдэж, шинжээчийг дахин томилуулах.

3.3. Гэрээний хавсралт бүхий баримт бичгийн үнэн зөвийг хариуцах.

3.4. Магадлалын ажилд шаардагдах хууль эрх зүйн баримт бичиг, материалыг тухай бүр цаг хугацаанд нь үнэн зөв гаргаж өгөх.

3.5. Магадлалын дүгнэлтийн дагуу төмөр замын суурь бүтцийн зураг төслийг хянан нягталж, Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний хугацаанд багтаан холбогдох залруулгыг хийж, тодруулга тайлбарыг гаргасан байх.

3.6. Энэхүү гэрээний 1.4-д заасан хугацаатай уялдуулан орон тооны бус Шинжээчийн гаргасан дүгнэлтийн дагуу залруулга (засвар)-ыг ажлын 6 хоногт багтаан хийж дуусган, Шинжээчээр хянуулж, баталгаажуулан, Гүйцэтгэгчид хүргүүлсэн байх.

ДӨРӨВ. ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

4.1. Зураг төслийн баримт бичигт магадлал хийх явцад ажлын шаардлагаар гэрээ сунгах бол тухай бүр тэмдэглэл хөтөлж, гэрээний биелэлтийг дүгнэж, сунгах эсэх асуудлыг талууд тохиролцсоны үндсэн дээр шийдвэрлэнэ.

4.2. Зураг төслийн магадлалын ажлыг гүйцэтгэх явцад энэхүү гэрээний 3.6-д заасан хугацааг хэтрүүлсэн бол хугацаа хэтэрсэн хоног тутамд зураг төслийн магадлалын ажлын төлбөрийн дүнгийн 0.4 хувиар алдангийг тооцно.

4.3. Зураг төслийн баримт бичигт магадлал хийх хугацаанд байгалийн давагдашгүй хүчин зүйл тохиолдсон нөхцөлд зайлшгүй нотлох баримтыг үндэслэн хоёр тал харилцан тохиролцож асуудлыг шийдвэрлэнэ.

ТАВ. МАРГААНЫГ ШИЙДВЭРЛЭХ

5.1. Талууд гэрээний үүргээ биелүүлээгүйгээс үүссэн маргааныг аль болох зөвшилцөх замаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ.

5.2. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадаагүй тохиолдолд маргааныг Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

Гүйцэтгэгчийг төлөөлж:

Захиалагчийг төлөөлж:

Хариуцсан нэгжийн дарга

.....
.....

Хариуцсан ахлах мэргэжилтэн

Утас:

Хариуцсан ахлах мэргэжилтэн

Имэйл:

Хаяг:

Утас: (51) 261196

Имэйл: magadlal@railway.gov.mn

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Энхтайваны
гүүр 11, Гэрэгэ тауэр 4-р давхар

ЗУРАГ, ТӨСЛИЙН БАРИМТ БИЧИГТ МАГАДЛАЛ
ХИЙХ ГЭРЭЭНИЙ СУНГАЛТ /ЗАГВАР/

1.1. Зураг төслийн баримт бичигт магадлал хийх явцад байгалийн давагдашгүй хүчин зүйлд өртсөн болон ажлын шаардлагаар гэрээ сунгасан тухай тэмдэглэлийг хоёр тал харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

1.2. Гэрээг сунгах болсон тухай тэмдэглэл:

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

ГЭРЭЭ СУНГАСАН:

Гүйцэтгэгчийг төлөөлж:

Захиалагчийг төлөөлж:

Хариуцсан нэгжийн дарга

.....

.....

Хариуцсан ахлах мэргэжилтэн

Утас:

Хариуцсан ахлах мэргэжилтэн

Имэйл:

Хаяг:

Утас: (51) 261196

Имэйл: magadlal@railway.gov.mn

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Энхтайваны
гүүр 11, Гэрэгэ тауэр 4-р давхар

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Төмөр
замын газрын даргын 2025 оны ... сарын ...-ны
өдрийн дугаар тушаалын гуравдугаар
хавсралт

ЗУРАГ, ТӨСЛИЙН БАРИМТ БИЧГИЙН БҮРДЛИЙГ ХЯНАХ МАЯГТ

- Захиалагч байгууллага:*
- Объектын байршил:*
- Объектын нэр:*
- Хүчин чадал:*
- Хөрөнгө оруулалтын төрөл: **улсын төсвийн, хувийн, гадаад зээл тусламж /доогуур зурах/***
- Ерөнхий гүйцэтгэгчийн **РД:***
- Тусгай зөвшөөрлийн хүчинтэй байх хугацаа:*
- Ажилбарын төрөл:*
- Харилцах утас:*

№	утга	Баримт бичгийн товч утга	Хуудас /ш/	Тайлбар		
1	Үндсэн бичиг баримт	Газар эзэмших захирамж* -ийн мэдэгдэл/гэрчилгээний хуулбар/		*Хүсэлт гаргагч байгууллага бичнэ.		
2		Зураг төсөл боловсруулах даалгавар, огноо, дугаар		*Хүсэлт гаргагч байгууллага бичнэ.		
3		Зураг төсөл боловсруулах гэрээ, огноо, дугаар		*Хүсэлт гаргагч байгууллага бичнэ.		
4		Батлагдсан эх загвар зураг /Эскиз/		Тайлбар үзнэ үү		
5		Инженерийн нарийвчилсан судалгааны дүгнэлт				
6		Инженер геологийн баталгаажсан дүгнэлт, архивын дугаар, гүйцэтгэсэн инженер	*Хүсэлт гаргагч байгууллага бичнэ.			
7		Инженер-геодезийн ажлын дүгнэлт гүйцэтгэсэн инженер	*Хүсэлт гаргагч байгууллага бичнэ.			
8		Байгаль орчны нарийвчилсан үнэлгээ	*Хүсэлт гаргагч байгууллага бичнэ.			
	Гадна инженерийн хангамжийн техникийн нөхцлүүд		Олгосон байгууллага	Олгосон огноо /дугаар/	Хүчинтэй байх хугацаа	Тайбар
9	Хот байгуулалт, газар зохион байгуулалтын мэргэжлийн комиссын хурлын шийдвэр, газар олголтын схем		*	*	*	
10	Усны барилга байгууламж		*	*	*	
11	Дохиолол, холбоо		*	*	*	

	Зураг төслийн иж бүрдэл	Зургийн марк	Хуудасны формат	Хуудасны тоо	Зураг төсөл боловсруулсан аж ахуйн нэгж /туслан гүйцэтгэгч/	Зураг төсөл гүйцэтгэсэн инженер	2 дахь инженер шалгаж гарын үсэг зурсан эсэх	
15	З	Нүүр хуудас	НХ					
16		Дэвсгэр зураг	ДЗ					

17		Трассын хэвтээ муруй, шулууны хүснэгт	МШ						
18		Эргэц төлөвлөлт, эргэцийн схем	Э						
19		Дагуу ба хөндлөн огтлол	ДХО						
20		Хучилтын бүтээц, нэг маягийн огтлол	ХХ						
21		Шороон болон чулуун ордын судалгаа, байршил	ШО						
22		Газар шорооны хуваарлалт	ГШХ						
23		Хиймэл байгууламж	ХБ						
24		Гарц уулзвар	ГУ						
25		Тоноглол	Т						
26		Тайлбар бичиг	ТБ						
27		Техникийн шаардлага	ТШ						
28		Байгаль орчины нарийвчилсан үнэлгээ	БОНУ						
29		Инженер-геологийн дүгнэлт	ИГД						
30		Ажлын тоо хэмжээ	АТХ						
31		Төсвийн тооцоо	ТТ						
32		бусад	-						
37		Дохиолол, холбоо	Д-Х						
38		бусад	-						
39	Инженерийн шалгалт	Төсөв /улсын төсвийн хөрөнгө оруулалттай/ мян.төг							
40		Онцгой объектод байгаль орчины ерөнхий болон нарийвчилсан үнэлгээ хийгдсэн эсэх							
41	Холболт шалгалт	Холболт хийж буй зураг төслийн магадлал хийгдэж баталгаажсан өрөнхий дүгнэлтийн хуулбар							
42		Бусад							

ЗУРАГ ТӨСӨЛ ЗӨВШӨӨРӨЛЦСӨН БАЙЛАЛ:

Зөвшөөрөлцсөн байгууллагууд	№	Холбогдох газрууд	Тайлбар	
	1	Орон нутгийн захиргаа	*	
	2	Байгаль орчины байгууллага	*	
	3	Хот төлөвлөлтийн байгууллага	*	
	4	Дэд бүтцийн байгууллага	*	
	5	Холбоо, дулаан, цахилгаан шугам сүлжээний байгууллага	*	
	6	ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн	Жишээлбэл: Тусгай хамгаалалттай газар нутаг	
	7	Бусад	Байгууллагын захирал /гарын үсэг/	

Тайлбар: Эх загвар зураг гэсэн 4-р мөрөнд төмөр замын суурь бүтэц, гүүрийн хийц бүтээцийн онцлог, төрөл, овор хэмжээ, геометр үзүүлэлт зэргийг багтаасан байна.

* - Хүсэлт гаргасан байгууллага бөглөнө.

** - Тухайн зураг төслийн байгууллагын үндсэн ажилтан байна.

Хүлээн авсан:

Хүлээлгэн өгсөн:

..... оны сарын

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Төмөр
замын газрын даргын 2025 оны ... сарын ...-ны
өдрийн дугаар тушаалын дөрөвдүгээр
хавсралт

**ТӨМӨР ЗАМЫН СУУРЬ БҮТЦИЙН ЗУРАГ ТӨСӨЛД МАГАДЛАЛ ХИЙХ ШИНЖЭЭЧИЙН
ДҮГНЭЛТ, МАГАДЛАЛЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТИЙН МАЯГТ, ТЭДГЭЭРИЙГ
БАТАЛГААЖУУЛАХ ТЭМДЭГИЙН ЗАГВАР**

НЭГ. ШИНЖЭЭЧИЙН ДҮГНЭЛТИЙН МАЯГТ

1.1. Төмөр замын суурь бүтцийн зураг төсөлд магадлал хийсэн шинжээч дүгнэлтээ дараах маягтын дагуу гаргаж, баталгаажуулна.

Зураг төслийн баримт бичгийн МАГАДЛАЛЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТИЙН ХАВСРАЛТ №1

ЗУРАГ ТӨСЛИЙН БҮРДЛИЙН ХЭСГИЙН НЭР, МАРК, ХУУДАСНЫ ТОО

... оны сарын өдөр

№	Утга	Тайлбар
1	Объектын нэр	
2	Объектын байршил, хүчин чадал	
3	Зураг төслийн байгууллага	
Дүгнэлтийн товч утга: /Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 204 дүгээр тогтоолын 7-р зүйлээс/		
4	7.5.1. барилга байгууламжийн байршил тогтоосон шийдвэр, архитектур төлөвлөлтийн болон зураг төсөл боловсруулах даалгавар, эх загвар зураг, байгаль, цагуурын ерөнхий өгөгдлүүд, техникийн нөхцөл, холбогдох мэргэжлийн байгууллагатай зөвшилцсөн байдал;	
5	7.5.2. барилга, байгууламжийн архитектур төлөвлөлт, бүтээц, инженерийн хангамжийн шийдэл нь дагаж мөрдөж байгаа норм, дүрэм, стандарт, технологийн даалгавар, тоног төхөөрөмжийн паспорт, инженер-геологийн судалгааны дүгнэлт, техникийн нөхцөлийн дагуу зохиогдсон эсэх,	
6	7.5.3. барилга байгууламжийн байршил, хот төлөвлөлт, инженер-геологийн нөхцөл, байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, сонгосон байршил, талбайн инженерийн хангамжийн хувилбар, харьцуулсан тооцоо, сонгосон хувилбарын талаарх дүгнэлт;	
7	7.5.4. зураг төслийн төлөвлөлт, техникийн шийдэл нь материал, түлш, эрчим хүч, усны нөөцийг хэмнэлттэй ашиглах нөхцөлийг бүрдүүлсэн байдал;	
8	7.5.5. хөдөлмөр хамгаалал, техникийн аюулгүй ажиллагаа, орчны эрүүл ахуйн байдалд тавигдах стандартын шаардлага болон норм, дүрмийг баримталсан байдал;	
9	7.5.6. хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажиллаж, амьдрах нөхцөлийг хангасан төлөвлөлтийн шийдлийг тусгасан байдал;	
10	7.5.7. хөрсний бохирдлоос хүрээлэн байгаа орчныг хамгаалах, үйлдвэрийн бохирдсон усыг цэвэрлэж ашиглах боломж, гадагш хаяж байгаа бохирдсон агаар, ус норматив үзүүлэлтийг хангаж буй эсэх;	
11	7.5.8 инженерийн шугам сүлжээний уртын дагуух төлөвлөлтийн оновчтой шийдэл;	
12	7.5.9. барилга байгууламжийн гаднах ерөнхий төрх, архитектурыг хот төлөвлөлтийн шаардлагад нийцүүлэн орчны барилга байгууламжтай уялдуулсан байдал, эзлэхүүн болон талбайг үр ашигтай төлөвлөсөн байдал;	
13	7.5.10. барилгын ажлын зохион байгуулалтын болон барилга байгууламжийг буулгах, задлах ажил гүйцэтгэх зураг төсөлд хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны шаардлагыг тусгасан байдал.	
14	7.6. Магадлалын дүгнэлтэд хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийг үндэслэн төлөвлөлт, техникийн үндсэн шийдэл, эдийн засгийн үр ашигт мэргэжлийн үнэлэлт өгч, техник-эдийн засгийн үндэслэл, зураг төсөлд нэмж тусгах буюу хасах, өөрчлөх асуудлын талаар товч, тодорхой тусгана.	
Дүгнэлт бичсэн:		
Шинжээчийн № овог, нэр /гарын үсэг/		
20 . оны ... сарын -ны өдөр		

1.2. Төмөр замын суурь бүтцийн төслийн бүрдэл болох Төсвийн тооцоонд магадлал хийсэн шинжээч дүгнэлтээ дараах маягтын дагуу гаргаж, баталгаажуулна.

Зураг төслийн баримт бичгийн
МАГАДЛАЛЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТИЙН ХАВСРАЛТ №1
ЗУРАГ ТӨСЛИЙН БҮРДЛИЙН ХЭСГИЙН НЭР /Төсвийн тооцоо/

№	Утга	Тайлбар
1	Объектийн байршил, хүчин чадал	
2	Объектийн нэр, шифр	
3	Объектын бүрдлийн хэсгийн нэр, хуудасны тоо, гүйцэтгэсэн ААН байгууллага	
4	Төсвийн тооцооны праграмм, төсвийн тооцоог хийсэн байгууллагын нэр, гүйцэтгэсэн инженер	
5	Төмөр замын суурь бүтцийн барилга, засварын ажлын тоо хэмжээг үнэн зөв тодорхойлсон байдал	
6	Төсвийн тооцоонд ашигласан норм, норматив, үнэ үнэлгээ	
7	Төсвийн тооцооны арга. аргачлалын оновчтой байдал, төслөөр тодорхойлсон нөөцийг оновчтой ашигласан байдал	
8	Төсвийн тооцоо, түүний хэлбэржүүлэлтэд зайлшгүй оруулах шаардлагатай завсар, өөчлөлт	
	Дүгнэлтийн товч утга	
1	Төвийн тооцоо нь дагаж мөрдөж буй норм, дүрэм, стандартын дагуу, оновчтой зохиогдсон эсэх	
Дүгнэлт бичсэн: Шинжээчийн № овог, нэр /гарын үсэг/ оны ... сарын -ны өдөр		

Шинжээч дүгнэлтийг компьютероор 2 хувь бичиж, гарын үсэг, тамга тэмдгээ дарж баталгаажуулсан байна.

1.3. Төмөр замын суурь бүтцийн зураг төслийн бүрдэл болох Инженер-геологийн тайлан, дүгнэлтэд магадлал хийсэн шинжээч дүгнэлтээ дараах маягтын дагуу гаргаж, баталгаажуулна.

Зураг төслийн баримт бичгийн
МАГАДЛАЛЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТИЙН ХАВСРАЛТ №1
ЗУРАГ ТӨСЛИЙН БҮРДЛИЙН ХЭСГИЙН НЭР /Инженер-геологийн дүгнэлт/

№	Утга	Тайлбар
1	Объектын байршил, хүчин чадал	
2	Объектын нэр, шифр	
3	Хайгуул, судалгааны ажил гүйцэтгэх даалгавар	
4	Судалгааны ажил гүйцэтгэх дэвсгэр зураг	
5	Объектын бүрдлийн хэсгийн нэр, хуудасны тоо, гүйцэтгэсэн байгууллага	
6	Тооцоо, тооцооны программ, тооцсон байгууллагын нэр, гүйцэтгэсэн инженер	
7	Төлөвлөлт, техникийн шийдэл	
8	Буурь хөрсний инженер-геологийн дүгнэлтийн архив №, боловсруулсан инженер, хөрсний ерөнхий дүгнэлт, хөрсний усны түвшин, улирлын хөлдөлтийн гүн, газар хөдлөлтийн балл	
	Дүгнэлтийн товч утга	
1	Инженер-геологийн шийдэл нь дагаж мөрдөж буй норм, дүрэм, стандартын дагуу зохиогдсон эсэх	
Дүгнэлт бичсэн: Шинжээчийн № овог, нэр /гарын үсэг/ оны ... сарын -ны өдөр		

Шинжээч дүгнэлтийг компьютероор 2 хувь бичиж, гарын үсэг, тамга тэмдгээ дарж баталгаажуулсан байна.

1.4. Шинжээчийн дүгнэлтийн дагуу Зураг төслийн байгууллагаас төсөлд холбогдох засвар, өөрчлөлтийг оруулж, тайлангаа дараах маягтын дагуу гаргаж, шинжээчэд танилцуулна.

Зураг төслийн баримт бичгийн
МАГАДЛАЛЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТИЙН ХАВСРАЛТ №2

ЗУРАГ ТӨСЛИЙН БҮРДЛИЙН ХЭСГИЙН НЭР

.....
.....

... оны сарын өдөр

№	Утга	Тайлбар
1	Объектын нэр	
2	Объектын байршил, хүчин чадал	
3	Зураг төслийн байгууллага	

№	Шинжээчийн санал, илэрсэн алдаа зөрчил	Алдаа, зөрчлийг засаж, төсөлд загвар оруулсан туахай тайлбар, танилцуулга
1		
2		
Дүгнэлт бичиж, биелэлтийг шалгасан шинжээч №/овог, нэр/ ... оны ... сарын -ны өдөр Биелэлтийн тайлбар бичсэн/овог, нэр/ ... оны ... сарын -ны өдөр		

Шинжээч дүгнэлтийг компьютероор 2 хувь бичиж, гарын үсэг, тамга тэмдгээ дарж баталгаажуулсан байна.

ХОЁР. МАГАДЛАЛЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТИЙН МАЯГТ

1.1. Зам, замын байгууламжийн зураг төслийн баримт бичгийн магадлалын ерөнхий дүгнэлтийг дараах маягтын дагуу гаргаж, баталгаажуулна.

ТӨМӨР ЗАМЫН ГАЗАР**ЗУРАГ ТӨСЛИЙН БАРИМТ БИЧГИЙН
МАГАДЛАЛЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ**

20... оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар

Улаанбаатар хот
Утас: (51) 261196

Объектын нэр:		
Объектын байршил:		
Хүчин чадал:		
Захиалагч:		
Санхүүжилтийн эх үүсвэр:		
Зураг төслийн ерөнхий гүйцэтгэгчийн нэр:		
Регистрийн дугаар:		
Тусгай зөвшөөрлийн хүчинтэй байх хугацаа:		
Зураг төсөл боловсруулах үндэслэл:		
Газар эзэмшүүлэх, ашиглуулах эрх, олгосон захирамж, дугаар огноо:		
Зураг төсөл боловсруулах даалгавар, баталсан албан тушаалтан, дугаар, огноо:		
Зураг төслийн гэрээ, баталсан албан тушаалтан, дугаар, огноо:		
Техникийн нөхцлүүд:		
Дулаан хангамж, шугам сүлжээ:		
Усан хангамж, ариутгах татуурга:		
Цахилгаан хангамж:		
Дохиолол, холбооны шугам, сулжээ:		
Зөвшөөрөлцсөн байгууллагууд:		
Зураг төслийн бүрэлдэхүүн	Зураг төслийн гүйцэтгэсэн байгууллагын нэр:	Шалгасан шинжээчийн нэр:
Төмөр замын суурь бүтцийн инженерийн нарийвчилсан зураг төсөл		
Тайлбар бичиг		
Техникийн шаардлага		
Геодезийн тайлан		
Инженер-геологийн тайлан		
Ус зүйн судалгааны тайлан		
Ажлын тоо хэмжээ		
Төсөвт өртгийн тооцоо		
Материалын нөөц олборлох эх үүсвэрийн судалгаа		
Галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлын судалгаа		
Ерөнхий дүгнэлт:		

Төмөр замын суурь бүтцийн чигийн сонголт болон техник-эдийн засгийн үзүүлэлтүүд, зураг төслийн үндсэн төлөвлөлт, шийдэл, хучилтын бүтээцийн талаарх дүгнэлт:	
Боловсруулсан зураг төслийн сонгосон шийдэл, магадлалын явцад хийсэн нэмэлт, өөрчлөлтөөс шалтгаалах ур дунгийн талаарх тодорхой санал, дүгнэлт:	
Зураг төслийн талаар явуулж байгаа төрийн нэгдсэн бодлого, хууль тогтоомж, норм нормативын баримт бичгийг үндэслэн боловсруулсан төслийн сонгосон шийдэл, төслийг хэрэгжүүлснээр тарах ур дунгийн талаарх тодорхой санал, дүгнэлт:	
Эдийн засгийн ур ашиг, хөдөлгөөний аюулгүй байдал, экологийн хор хөнөөлгүй байдал, ашиглалтын үеийн найдвартай ажиллагаа, төсөвт өртгийн тооцооны талаарх дүгнэлт:	

Энэхүү журмын 13 дугаар зүйлийн 13.5 заасны дагуу Барилгын ажлын явцад зураг төслөөс шалтгаалсан алдаа гарсан, алдааг Төмөр замын газрын салбарын хяналт шалгалтын эрх бүхий этгээд акт тогтоосон тохиолдолд гэрээ болон холбогдох хууль журамд заасны дагуу зураг төслийг боловсруулсан байгууллагаар гарсан хохирлыг барагдуулах, тусгай зөвшөөрлийг цуцалж, хар жагсаалтад оруулах асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлэх арга хэмжээ авна.

Мөн 13.6 заасны дагуу Шинжээч нь энэхүү журам ба гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа норм, норматив, стандартыг зөрчсөн, алдаатай дүгнэлт гаргасан, зураг төслийн техникийн буруу шийдлийг засаж, залруулаагүй, мэргэжлийн болон ёс зүйн зөрчил удаа дараа гаргасан тохиолдолд шинжээчийн эрхийг цуцлах хүртэл арга хэмжээ авна.

.....нутаг дэвсгэрт баригдах “.....”-ны барилгын ажлын зураг төсөлд “Төмөр замын техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах, магадлал хийх, техник, технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээний журам”-ын дагуу орон тооны бус шинжээчид магадлал хийсэн болно.

Магадлалын ерөнхий дүгнэлт нь шинжээчүүдийн хавсралтхуудас дүгнэлтийн хамт хүчинтэй болно.


ХАРИУЦСАН НЭГЖИЙН ДАРГА /...../

ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН /...../

ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН /...../

**ГУРАВ. ШИНЖЭЭЧИЙН ДҮГНЭЛТ, МАГАДЛАЛЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТИЙГ
БАТАЛГААЖУУЛАХ ТЭМДГИЙН ЗАГВАР**

3.1. Шинжээчийн дүгнэлтийг баталгаажуулах тэмдгийн дардасны хэсгийг резинээр хийх бөгөөд тэмдэг нь 55х40 мм-ийн голчтой, зуйван дугуй хэлбэртэй, гадна давхар хүрээний дотор талд дараах бичвэртэй байна.



3.2. Магадлалын ерөнхий дүгнэлтийг баталгаажуулах тэмдгийн дардасны хэсгийг резинээр хийх бөгөөд тэмдэг нь 100х65мм-ийн дөрвөлжин хэлбэртэй, гаднаа давхар хүрээтэй, хүрээний дотор талд дараах бичвэртэй байна.



-о0о-

ТӨГСӨВ